Маягт -4

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙГ 2023 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ I УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 04 дүгээр сарын 07 Улаанбаатар хот

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ(сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтод түвшин, үр дүн (Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (Сая.төг) | Төсвий (Гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | | | | |
| 4.1.8 | НЗДҮАХ-5.1.2 | Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана. | - | УБЗАА, Дүүргүүд ХСХГ, | Дүүргийн төсөв | - | 488 | 506 | - | - | Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Хотын стандарт, хяналтын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 02-13-04/023/03 дугаар “Стандартын шаардлага хангахгүй эрсдэлтэй хүүхдийн тоглоомын талбайд урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага UCS1405B:2022, Хүүхдийн тоглоомын талбайн Ерөнхий шаардлага MNS6751:2019 стандартын дагуу тайлангийн хугацаанд нийт 86 хүүхдийн тоглоомын талбайг хамруулсан. Хяналт шалгалт үргэлжилж байна. | 30 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Хяналт шалгалтаар хүүхдийн тоглоомын талбайнуудад эзэмшигч, ашиглагч байгууллагууд тогтмол засвар үйлчилгээг хийгдэггүй, улирлын онцлогоос шалтгаалан тоглоомууд бохирдсон, тортог суусан, орчны хөрс бохирдолтой, зарим эд зүйлс эвдэрсэн зөрчлүүд түгээмэл илэрч байна. Цаашид зөрчилтэй тоглоомын талбайн эзэмшигчдэд улсын /ахлах/ байцаагчдын албан шаардлага, зөвлөмж хүргүүлэхээр ажиллаж байна. | |
| 4.2.5 | НЗДҮАХ-5.2.1 | Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Агаарын чанарын стандарт”-ыг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлнэ. | - | ХСХГ | Нийслэлийн төсөв | 50.0 | - | 1 | - | - | Тус ажлыг 2 дугаар улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. | - |
| 4.3.21 | НЗДҮАХ-5.3.6 | “Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага”, “Хөв цөөрөм үүсгэх болон хур тунадасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага” баримт бичгийг батлуулж, хэрэгжилтийг хангуулна. | - | ХСХГ, УБЗАА | Нийслэлийн төсөв | - | - | 2 | - | - | Иргэдийн эрүүл, аюулгүй амьдралыг орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд хотын стандартыг боловсруулж, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах, мөрдүүлэх цогц арга хэмжээ нь 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар дараах үзүүлэлттэй байна. Үүнд: Батлуулж, мөрдүүлж эхэлсэн- 9 бүлгийн 38, 2 дугаар ээлжээр батлуулсан-7 бүлгийн 14, өргөн барихаар бэлтгэл хангаж буй 15 хотын стандартын төсөл тус тус байна. Үүнд: | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | "Хөв цөөрөм үүсгэх болон хур тунадасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага", "Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага" стандартын төслийг боловсруулж дууссан ба 2023 ондоо багтаж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барихаар төлөвлөж байна. | |
| 4.3.22 | НЗДҮАХ-5.3.6 | Орон сууцны хороолол дахь ногоон байгууламжийн техникийн ерөнхий шаардлага баримт бичгийг батлуулж, хэрэгжилтийг хангуулна. | - | ХСХГ | Нийслэлийн төсөв | - | - | 1 | - | - | Байгууллагын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан Орон сууцны хороолол дахь ногоон байгууламжийн хүртээмжийн судалгааг "Статистик дэвшил" ТББ-р хийлгэсэн бөгөөд судалгааны үр дүнг энэ оны 2 дугаар улиралд олон нийтэд танилцуулах зорилгоор байгууллагын цахим хуудсанд байршуулахаар ажиллаж байна. | 70 |
| 4.3.23 | НЗДҮАХ-5.3.6 | Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага баримт бичгийг батлуулж, хэрэгжилтийг хангуулна. | - | ХСХГ | Нийслэлийн төсөв | - | - | 1 | - | - | 2022-2023 онд боловсруулсан, одоогоор хянан тохиолдуулж буй 15 хотын стандарт байна. Үүнд: "Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага" багтаж байна. 2023 ондоо багтаж Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барихаар төлөвлөж байна. | 70 |
| 4.3.24 | НЗДҮАХ-5.3.6 | Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын хөрсөнд дахин сэргээлт хийх ерөнхий шаардлага, удирдамж арга зүйн баримт бичгийн төсөл боловсруулж, мөрдүүлнэ. | - | ХСХГ | Нийслэлийн төсөв | 250.0 | - | 1 | - | - | 2022-2023 онд боловсруулсан, одоогоор хянан тохиолдуулж буй 15 хотын стандарт байна. Үүнд: "Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх гарын авлага" багтаж байна. 2023 ондоо багтаж Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барихаар төлөвлөж байна. | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.22 | НЗДҮАХ-6.1.4 | Хотын стандартыг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмын төсөл боловсруулж батлуулан мөрдүүлж эхлүүлнэ. | - | ХСХГ | - | | - | 100 | - | - | Хотын стандарт боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын төслийг боловсруулан нутгийн захиргааны 12 байгууллагаас ирүүлсэн саналыг тусган Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 70 |
| 5.1.24 | НЗДҮАХ-6.1.7 | Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд орон сууцны барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ. | - | ХБХГ, ХСХГ | Төр, хувийн хэвшлийн | - | - | 19864 | - | - | Барилга угсралтын ажил эхлээгүй байна. Тус ажлыг 2 дугаар улирлаас эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. | - |
| 6.1.27 | НЗДҮАХ-6.1.5 | Нийслэлийн авто зам, тээврийн салбарт мөрдүүлэх хотын стандартыг боловсруулж батлуулна. | - | ХСХГ | Нийслэлийн төсөв | 300.0 | - | 3 | - | - | Нийслэлийн авто зам, тээврийн салбарт мөрдүүлэх шаардлагатай хотын стандартыг тодорхойлох судалгааг эхлүүлсэн. | 30 |
| Дундаж биелэлт | | | | | | | | | | | | 45% |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Э.ДАВААХАТАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.ДААРИЙМАА